

Дисковер Монголиа – 2013

Оюу Толгой ХХК-ийн Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх ерөнхий захирал

Камерон МакРейн илтгэл

2013 оны есдүгээр сарын 5

Эрхэм хүндэт Уул уурхайн сайд,

Эрхэм хүндэт зочид, төлөөлөгчид өө.

Өнөөдөр та бүхэнтэй уулзахад маш таатай байна.

Дисковер Монголиа чуулга уулзалтыг Оюу Толгой компани ес дэх жилдээ ивээн тэтгэж байгаад баяртай байна. Миний хувьд энэхүү өндөр ач холбогдол бүхий чуулга уулзалтад Рио Тинто, Оюу Толгой ХХК-ийг төлөөлөн сүүлийн удаа оролцож байна. Миний бие Оюу Толгойн захирлын албаа ирэх сард хүлээлгэж өгнө. Өнөөдрийн илтгэлээрээ Монгол улсад гурван жилийн хугацаанд хийж бүтээсэн ажлынхаа тухай олон нийттэй хуваалцах сүүлийн боломж гэж бодож байна.

Иймд өнөөдөр та бүхэнтэй зөвхөн өөрийнхөө ажилласан 3 жилийн тухай биш, харин Оюу Толгойд сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд өрнөсөн нүсэр бүтээн байгуулалтын тухай санал бодлоо хэлье.

Мэтгэлцээн, хэлэлцүүлэг үргэлжилж байгаа өнөө үед, гарсан сургамж, цаашдын төлөв байдлын талаар ч ярих хэрэгтэй гэж үзэж байна.

Оюу Толгой нь хөгжлийн явцдаа маш олон саад, бэрхшээлийг даван туулсан түүхтэй. Мөн энэ компанийн түүхийг бүтээлцэхэд асар их итгэл үнэмшил, хүсэл эрмэлзэл, хүчин чармайлт, оролцоо шаардагдсан. Энэ бүтээн байгуулалтад хувь нэмрээ оруулсан олон хувь хүн, байгууллагыг бид мартах ёсгүй.

- Хамгийн түрүүнд, энд олон жил хамтарч ажилласан олон улсын болон монгол геологичдыг дурьдах хэрэгтэй. Газар дор нууцлагдмал баялаг байгааг тэд л анх олж илрүүлсэн. Тэд л гурван хэсэг томоохон зэсийн нөөц, хоёр томоохон усны нөөцийг олж илрүүлсэн. Харин өнөөгийн амжилт тийм ч түргэн, бас хямдхан олдоогүй. Тэд анхнаасаа маш том боломжтой төсөл гэсэн итгэл үнэмшилд хөтлөгдсөн. Хайгуулын ажил үр дүн тэй болно гэдэгт Айвэнхоу Майнз компани итгэж, хайгуул, бүтээн байгуулалтын ажилд зарцуулах асар их хөрөнгийг босгож чадсан юм.
- Мөн Оюу Толгойн өнөөдрийн амжилтыг урьдчилан харж чадсан дэмжигчид, ялангуяа өөрийн нэр хүнд, албан тушаалаар ч дэнчин тавьж шинэ юм бүтээж чадна гэдэгт итгэсэн улстөрчдийг дурьдмаар байна. Оюу Толгой асар том, маш өвөрмөц төсөл учраас ихээхэн улстөрийн зориг, алсын хараа шаардагдаж байлаа. Тэд Оюу Толгой төслийг эхлүүлэхэд бизнесийн өвөрмөц загвар шаардлагатай болохыг олж харсан. Мөн Оюу Толгой төслийн үр өгөөжийн тухайд хойч үеийнхэн л илүү сайн үнэлэлт, дүгнэлт өгнө гэдгийг тэд мэдэж байсан.
- Тийм ээ, шинэ зүйл бүтээж яваа нэгнээ шүүмжлэх, эсвэл гараа хүмхиад суух нь хэзээд амар хялбар байдаг. Оюу Толгойн бүтээн байгуулалтыг дэмжиж ирсэн эдгээр хүмүүс энэхүү шинэ үйл явцын үнэ цэн, боломжийг харсны төлөө богино хугацаанд асар их шүүмжлэлд өртөх болно гэдгийг сайтар ухаарсан биз ээ. Гэхдээ Оюу Толгой төсөл нь түүхэнд тохиож байгаагүй эдийн засгийн өсөлт, хөгжлийн шинэ үеийг нээх болно гэж тэд үзэж байсан нь харин бодит үнэн болсон юм. Монгол улсад хөгжлийн шинэ үеийг Оюу Толгой төсөл авч ирж чадсан гэдэгт хэн ч маргахгүй байх. Төсөл богино хугацааны үр ашгаа өгч байгаа нь нэгэнт тодорхой болсон. Харин үрт хугацааны үр ашиг дөнгөж эхэлж байна гэж ойлгож болно.

- Рио Тинтод ч уг төслийн болон Монгол Улсын ирээдүйд итгэсэн удирдагч менежерууд байна. Сүүлийн гурван жилийн турш Рио Тинто компани үнэнч, тууштай ажиллаж ирсэн нь үүний нотолгоо юм. Өнөөдрийн томоохон шинэ бизнесийг бий болгоход энэхүү итгэл үнэмшил маш чухал байлаа.

1996 оноос эхэлсэн уг төслийн явцад хөрөнгө оруулалтаараа эрсдэл хүлээсэн эсвэл хууль эрхзүйн болон нийгмийн орчинг бий болгоход хувь нэмрээ оруулсан хүн бүр бидний талархлыг хүлээх бүрэн эрхтэй.

Хэдэн тэрбум доллараар яригдах хөрөнгө оруулалт тийм амар хийгдэхгүй нь мэдээж. Олон сая жил газрын гүнд бүрэлдсэн гайхамшигтай ордыг олж илрүүлсэнээс хойш гуравхан жилийн дотор Оюу Толгойг ашиглалтад орууллаа. Гэхдээ 2010 оноос хойш эхэлсэн төсөл тийм ч дардан замаар яваагүй.

Гурван жилийн хугацаанд дотоодын болон олон улсын нөөц бололцоог хэрхэн дайчилж ашиглан, юу бүтээж болохыг Оюу Толгой харууллаа.

Эрс тэс үүр амьсгалтай, дэд бүтэц хараахан хөгжөөгүй газарт дэлхийн төвшний үүрхайг төлөвлөсөн хугацаанаас нь өмнө аюулгүй ажиллагааг бүрэн ханган барьж, одоо бүрэн хүчин чадлаараа ажиллах төвшинд хүрээд байна.

Гэхдээ энэ хөрөнгө оруулалт зөвхөн 17 мянган залуусыг ажилтай, орлоготой болгох, цемент зуурах, ган төмөр хийц угсрах, газар шорооны ажил хийх, ачааны машин цуглуулах, асар том тээрэм барих зэргээр огт хязгаарлагдаагүй юм.

Тиймээ, бид дэд бүтэц сул хөгжсөн, хөдөө талд томоохон ил үүрхай, авто зам, цахилгаан дамжуулах агаарын шугам, нисэх буудал зэргийг барьж усны нөөцийн эх үүсвэрийг илрүүлсэн.

Бид орон нутгийг хөгжүүлэх чухал дэд бүтэц бий болгож, эрүүл мэндийн хөтөлбөрүүдийг дэмжин, боловсролын салбарт 125 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж ирээдүйн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэж байна. Энэ нь зөвхөн Оюу Толгойн тусын тулд бус улс орны цаашдын тусын тулд хийгдэж байгаа юм.

Эдгээр амжилтын ихэнхи нь сүүлийн хэдэн жилд гарсан боловч, Оюу Толгой төсөл үүнээс ч урт удаан түүхтэй юм.

7 жилийн турш 5 удаа оролдлого хийсний үр дүнд Хөрөнгө оруулалтын гэрээг байгуулсан. Тухайн үед нэг тэрбум гаруй ам.долларын хөрөнгө оруулалтыг хийчихээд байсан.

Хөрөнгө оруулалтын гэрээ, хувь нийлүүлэгчдийн гэрээ хоёр нь барилга бүтээн байгуулалтыг эхлүүлэхэд шаардлагатай тогтвортой байдал, үйл ажиллагаа явуулах хууль эрхзүйн хүрээг хангаж өгч байлаа.

Хөрөнгө оруулалтын гэрээ нь заавал бүгд нэг саналд хүрэхийг шаардахгүйгээр, нэгдсэн ойлголтод хүрэхийн төлөө хамтран ажиллах, өрөөл бүсдын өөр санал бодлыг хүндэтгэхийн зэрэгцээ түншлэлийн ашиг тусыг дээшлүүлэх нэг ёсны баталгаа болсон гэж хэлж болно.

Энэхүү тэнцвэрийг зөв олох нь чухал ач холбогдолтой. Учир нь Монгол улсад аливаа салбарт хөрөнгө оруулах бусад хөрөнгө оруулагчид Оюу Толгой төслөөс үлгэр жишээ авч байна.

Гэхдээ Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан ч Оюу Толгой төслийн хөрөнгө оруулагчдын хувьд томоохон геополитикийн сорилт тулгарч байсан билээ. ОХУ-аас түлш оруулах, Хятадаас эрчим хүч импортлох, баяжмалаа дэлхийн зах зээлд борлуулах баталгаатай гэрээ хэлцэл байгуулагдаагүй байлаа. Мөн Монгол улсаас түүхий эд гаргах, уул уурхайн тоног төхөөрөмжийг Монгол руу тээвэрлэхэд асар том ложистикийн бэрхшээл тулгарч байв.

Хөрөнгө оруулагчид энэ төслийн ирээдүйд итгэж байсан тул эдгээр эрсдэлийг хүлээхэд бэлэн байлаа. Хоёрдугаар шатны Төслийн санхүүжилт тодорхойгүй байсан 2010 онд ч эрсдэл хүлээж уг төслийг эхлүүлж байсан, эдгээр хөрөнгө оруулагчид. Тиймээс ч эрсдлийг дааж тэд хөрөнгөө оруулсан.

2013 оны 7 дугаар сард анхны зэсийн баяжмалаа дэлхийн зах зээлд экспортлож эхлэх үед бид энэ төслөөс анх удаа орлого олж эхэлсэн. Гэхдээ цаг хугацаа, тэвчээр гарган энэ төслийн талаар маш удаан хэлэлцсэний үр дүнд Оюу Толгой эхлэл үедээ шууд үр өгөөжөө өгсөн.

- Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулснаас хойш гадаадын шууд хөрөнгө оруулалт 11 дахин өсч, бусад олон төслүүдийн санхүүжилт бий болоход тус дэм боллоо.
- Оюу Толгой анхны орлогоо олохоос өмнө Монгол улсын Засгийн газар, төсөвт байгууллагуудад нийт 1.1 тэрбум гаруй ам. долларын татвар, хураамж, бусад төлбөрийг төлсөн.
- Цахилгаан эрчим хүч, зам зэрэг орон нутгийг хөгжүүлэх дэд бүтэц бий болгож олон хүний аж амьдралд эерэгээр нөлөөлсөн.
- Мөн олон мянган монголчууд өндөр цалинтай, чанартай ажлын байртай болж, олон хүн улс даяар компанийн тэтгэлэгээр мэргэжилтэй боловсон хүчин болохоор сурч байна.

Оюу Толгой төгс байсан уу гэвэл мэдээж үгүй. Оюу Толгой бол Монгол улсын хувьд ч, олон улсын хөрөнгө оруулагчдын хувьд ч, уул уурхайн салбарын хувьд ч шинэ түршлага юм.

Бүх талд сурах зүйл, авах сургамж их байна. Шийдвэрлэх асуудлууд ч үлдэж байгаа.

Тухайлбал, ирээдүйн том болон жижиг төслүүдэд бизнесийн үйл ажиллагааг дэмжсэн орчинг хэрхэн бүрдүүлэх вэ гэсэн асуулт байна.

- Мэдээж бизнесийн үйл ажиллагаанд тодорхой дэмжлэг хэрэгтэй. Үйл ажиллагаа нь дөнгөж эхэлж байгаа үед нь зөвшөөрөл, лиценз олгох ажил удааширвал уг бизнес сөхрөөд уначих зовлон бий. Бидний түршлагаас харахад энэ асуудал шийдвэрлээгдээгүй хэвээр байна, үүнд яаралтай анхаарал хандуулах шаардлагатай байна.

Цаасан дээр байсан стратегийн том төслүүдийг бодит амьдрал дээр хэрэгжүүлэхэд тус дэм болох улстөрийн болон олон нийтийн хэлэлцүүлгийг хэрхэн эхлүүлж болох вэ гэсэн бас нэг асуулт байна.

Дотоодын болон олон улсын хөрөнгө оруулагчдын илтгэл үнэмшлийг дээшлүүлэх нь үүний хариулт болох ёстой байх.

Хамгийн чухал нь бидний өгсөх, уруудах нь энэхүү нэгдсэн зорилго, нийтлэг үнэт зүйлсээ хамтран олж ашиглаж чадах эсэхээс шалтгаална.

Уул уурхайн томоохон төслүүдээсээ илүүтэйгээр бусад олон төслүүд хөгжсөн хүчирхэг эдийн засагтай, тэр эдийн засгийнх нь багахан хэсэг нь Оюу Толгой болж хөгжөөсэй гэж би хүсдэг, энэ тухайгаа ч өмнө нь дурьдаж байсан.

Гэхдээ Оюу Толгой өөрөө асар том учраас бусад Монголд бизнес, хөрөнгө оруулалтын төслийн хувьд хүрч болох амжилтын үлгэр дууриал болж байна.

Оюу Толгой олон нийтийн анхаарлын төвд байгаа нь ийнхүү мэтгэлцээн, хэлэлцүүлэг байнга дагалдаж байгаа нь тодорхой, бас талуудад их чухал ач холбогдолтой.

Харин энэхүү хэлэлцүүлгийн уур амьсгал заримдаа талуудад тус болохоосоо илүү үс болсон тохиолдол ч бий.

- Оюу Толгойн хувьд – Оюу Толгой төслийг дэлхийн зиндааны бизнес бий болгох асуудалд гол анхаарлаа хандуулж ажиллах ёстой байсан.
- Засгийн газрын хувьд – Оюу Толгойн асуудлаас болж бусад чухал бодлогын чиглэлд тавих анхаарлаа сарниулахад хүргэсэн.
- Нийт ард иргэдийн хувьд – Хүн бүр Оюу Толгой төслөөс Монгол улс хамгийн өндөр ашиг тусын төлөө дуугарсан.

Оюу Толгойн ирээдүйд энэ түүх давтагдах ёсгүй.

Оюу Толгойн ирээдүй бол улстөрийн дуусашгүй маргаан биш, цэвэр бизнесийн үйл ажиллагаа байх ёстой.

- Харин уг бизнес нь нээлттэй, ил тод, нийгмийн өндөр хариуцлагатай байх ёстой. Нийгмийн нарийн хяналт шаардлагатай байсан ч аливаа хэлэлцүүлэг нь ажил хэрэгч байдалтай байхаас гадна зөв мэдээлэлд үндэслэсэн байх ёстой.

Энэ бол бидний хувьд шийдвэрлэх мөч гэж би хувьдаа үзэж байна. Талууд асуудлуудаа шийдвэрлэж, Оюу Толгой төслийг хамтран үргэлжлүүлж хөгжүүлэхийн төлөө гэсэн нэгэн зүйлийг л хүсч байгаа гэдэгт би итгэж байна. Манай хувь нийлүүлэгчид яриа хэлэлцээрээ үргэлжлүүлж байгаа ч асуудлыг шийдвэрлэхэд тодорхой цаг хугацаа шаардаж байгааг ойлгон, хүлээн авна уу.

Далд уурхайн бүтээн байгуулалтын ажилд шаардагдах нэмэлт санхүүжилт байхгүй байсан учраас үйл ажиллагааг зогсоох болсон нь миний хувьд хамгийн хүнд шийдвэр байлаа. Гэхдээ хувь нийлүүлэгчид эдгээр асуудлуудыг шийдвэрлэж чадна гэдэгт би итгэлтэй байна. Та бид бүгдээрээ далд уурхайн бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх сонирхолтой байгаа. Энэ бол Оюу Толгой төслийн нэгэн онцлог, энэ бол хойч үеийнхэн ч төслийн үр дүнг урт удаан хугацаанд хүртэх баталгаа мөн.

Эдийн засгийн хүндрэл, дэлхийн зах зээлийн цаашдын чиг хандлага тодорхойгүй байгаагаас үл хамааран Монгол улсын хувьд энэ цаг мөч сонирхолтой хэвээр байна. Энд цугларсан та бүгд ч үүнд чухал үүрэг гүйцэтгэх болно гэдэгт гүнээ итгэж байна.

Шинэ сэтгэлгээ, шинэ санаа гарч байна, нийгмийн хэлэлцүүлэг ч Монгол Улсын эдийн засгийн ирээдүйн талаар шинэ, эерэг дүр зураг бий болгох чиглэл рүү шилжиж байна.

Одоогийн байдлаар зам, төмөр замын дэд бүтэц, эрчим хүч, уул уурхайн төсөл зэрэг нийт 40-60 тэрбум ам.долларын өртөгтэй төслүүд энд яригдаж байна.

Зөв нөхцөл байдал бий болж, эдийн засгийн ухаалаг бодлого, улстөрийн урам зориг нь томоохон төслүүдийг урагшлуулж нэн шаардлагатай эерэг үлгэр жишээ бий болгож чадвал эдгээр бүх төслүүдийг бизнесийн байгуулагууд хэрэгжүүлэхэд бэлэн байна.

Албан тушаалаа өгч байгаа энэ цаг мөчид миний бие Оюу Толгойн багийн болон түүний түншүүдийн хувьд сүүлийн гурван жилийн туршид хийж бүтээж чадсан, гаргасан амжилтаараа маш их бахархаж байна. Миний өмнө ажиллаж байсан хүмүүс, мөн Рио Тинто, Туркойз Хилл буюу хуучнаар Айвэнхоу Майнз компанийн хамтран зүтгэгчдийн хувь нэмрийг өндрөөр үнэлж байна. Миний албыг үргэлжлүүлэх шинэ захиралд ч шийдвэрлэх нэлээдгүй олон асуудал үлдэж байгаа үед ажлаа хүлээлгэн өгч байна.

Гэхдээ шинэ захирлын хувьд ямар гайхамшигтай улс оронд ажиллаж байгаагаа ойлгох байх.

- Залуу, маш их боловсролтой ажиллах хүчинг бид бүрдүүлсэн – тэд улс орныхоо хөгжилд оруулж буй хувь нэмрээрээ бахархах бүрэн эрхтэй.
- Бидний ханган нийлүүлэгчдийн сүлжээ хүмүүсийн амьжиргаанд өөрчлөлт авч ирэх Монголын жижиг дунд үйлдвэрийн шинэ үеийнхнээс бүрдэж байна.
- Тиймээ, бид олон сорилт, бэрхшээлтэй тулгарч байна, бидний ажиллах орчин илүү их овсгоо самбаа, хийж бүтээж чадна гэсэн өөдрөг сэтгэлгээг шаардаж байна.
- Хамгийн чухал нь, бахархал бүхий нэгэн шинэ Монгол компанийг удирдан гэрэлт ирээдүйг бий болгох сайхан боломж Оюу Толгойн шинэ захиралд гарч байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.